

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/78/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Алтай хот

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413

Аудитын менежер:

Утас: 70484055

Ахлах аудитор:

Утас: 99177546

Аудитор:

Утас: 99026016

Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)

Д.Эрдэнэчимэг

Цахим хаяг: [erdenechimegd@audit.gov.mn](mailto:erdenechimegd@audit.gov.mn)

Ж.Бүжинханд

Цахим хаяг: [Vujinkhandj@audit.gov.mn](mailto:Vujinkhandj@audit.gov.mn)

Б.Цэвэлмаа

Цахим хаяг: [Tsevelmaab@audit.gov.mn](mailto:Tsevelmaab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт.....	13
4.1 Залруулсан алдаа .....	13
4.2 Төлбөрийн акт.....	13
4.3 Албан шаардлага .....	13
4.4 Зөвлөмж .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 72

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

070.20366

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>63,913,222.90</b>	<b>106,207,518.90</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>45,629,388.00</b>	<b>102,000,684.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,956,533.00	7,705,372.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>40,672,855.00</b>	<b>94,295,312.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	30,022,046.00	83,644,503.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	10,650,809.00	10,650,809.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>18,283,834.90</b>	<b>4,206,834.90</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>15,820,500.00</b>	<b>1,577,500.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	15,820,500.00	1,577,500.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>2,463,334.90</b>	<b>2,629,334.90</b>
35410	Бичиг хэргийн материал	321,000.00	436,000.00
35420	Аж ахуйн материал	390,000.00	441,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,752,334.90	1,752,334.90
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>119,454,738.83</b>	<b>862,516,255.22</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>119,454,738.83</b>	<b>862,516,255.22</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>119,181,239.00</b>	<b>862,376,255.22</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	444,189,500.00	1,207,033,215.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-444,189,500.00	-447,538,432.54
39203	Авто-тээврийн хэрэгсэл	85,900,000.00	55,100,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-26,913,333.36	-31,580,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	65,632,488.19	99,439,688.19
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13,613,348.89	-27,276,103.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,139,986.00	13,139,986.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,028,622.94	-9,006,168.42
39217	Ном	3,064,070.00	3,064,070.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>273,499.83</b>	<b>140,000.00</b>
39301	Програм хангамж	3,680,000.00	3,680,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,406,500.17	-3,540,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>183,367,961.73</b>	<b>968,723,774.12</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>183,367,961.73</b>	<b>968,723,774.12</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>183,367,961.73</b>	<b>968,723,774.12</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	167,934,685.73	167,934,685.73
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>15,433,276.00</b>	<b>800,789,088.39</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-79,506,604.99	15,433,276.00
51220	Тайлант үеийн үр дүн	94,939,880.99	785,355,812.39
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>183,367,961.73</b>	<b>968,723,774.12</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,116,234,822.85</b>	<b>3,534,367,450.96</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>148,916,405.85</b>	<b>816,552,174.96</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>148,916,405.85</b>	<b>816,552,174.96</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>148,916,405.85</b>	<b>0.00</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	148,916,405.85	0.00

**Говь-Алтай аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	768,705,015.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	47,847,159.96
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,967,318,417.00</b>	<b>2,717,815,276.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,815,422,700.00</b>	<b>2,204,782,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,815,422,700.00	2,204,782,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>151,895,717.00</b>	<b>513,033,176.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	111,493,857.00	216,812,415.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,721,000.00	95,020,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,672,480.00	201,180,761.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,008,380.00	20,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,021,294,941.86</b>	<b>2,723,344,971.97</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,021,294,941.86</b>	<b>2,723,344,971.97</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>564,365,591.86</b>	<b>847,145,471.97</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>286,827,356.00</b>	<b>239,335,186.00</b>
210101	Үндсэн цалин	218,472,056.00	170,979,886.00
210102	Нэмэгдэл	53,326,400.00	53,326,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,088,000.00	11,088,000.00
210104	Урамшуулал	3,940,900.00	3,940,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>35,167,261.00</b>	<b>30,773,575.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,791,661.00	22,037,475.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,593,900.00	2,184,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,075,100.00	1,747,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	518,800.00	436,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,187,800.00	4,368,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>31,300,000.00</b>	<b>28,500,000.00</b>
210302	Түлш, халаалт	11,600,000.00	6,423,370.00
210304	Байрны түрээс	19,700,000.00	22,076,630.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>65,363,555.45</b>	<b>59,110,802.96</b>
210401	Бичиг хэрэг	3,498,700.00	2,887,900.00
210402	Тээвэр, шатахуун	4,484,000.00	3,855,443.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	622,600.00	679,200.00
210404	Ном, хэвлэл	0.00	192,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	370,800.00	315,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,426,300.00	3,333,200.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	53,961,155.45	47,847,159.96
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,620,000.00</b>	<b>4,561,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,350,000.00	4,561,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>142,087,419.41</b>	<b>484,864,908.01</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	278,800.00	239,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	128,895,017.00	456,702,576.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,913,602.41	27,922,732.01
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,456,929,350.00</b>	<b>1,876,199,500.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,429,580,025.00</b>	<b>1,721,816,712.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	735,432,937.00	1,055,708,958.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	693,547,088.00	665,607,754.00

**Говь-Алтай аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>27,349,325.00</b>	<b>154,382,788.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,349,325.00	154,382,788.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>94,939,880.99</b>	<b>811,022,478.99</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>25,666,666.60</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	25,666,666.60
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>94,939,880.99</b>	<b>785,355,812.39</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	167,934,685.73	4,113,184.60	-83,619,789.59	88,428,080.74
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	4,113,184.60	4,113,184.60
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	167,934,685.73	4,113,184.60	-79,506,604.99	92,541,265.34
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-4,113,184.60	0.00	-4,113,184.60
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	94,939,880.99	94,939,880.99
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	167,934,685.73	0.00	15,433,276.00	183,367,961.73
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	167,934,685.73	0.00	15,433,276.00	183,367,961.73
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	167,934,685.73	0.00	15,433,276.00	183,367,961.73
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	785,355,812.39	785,355,812.39
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	167,934,685.73	0.00	800,789,088.39	968,723,774.12

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,975,199,367.00</b>	<b>2,723,695,276.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,975,199,367.00</b>	<b>2,723,695,276.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,815,422,700.00	2,204,782,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,815,422,700.00	2,204,782,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>159,776,667.00</b>	<b>518,913,176.00</b>

**Говь-Алтай аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	111,493,857.00	216,812,415.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,721,000.00	95,020,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,672,480.00	201,180,761.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,889,330.00	5,900,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,964,678,367.00</b>	<b>2,695,749,376.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,964,678,367.00</b>	<b>2,695,749,376.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>507,749,017.00</b>	<b>819,549,876.00</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,889,200.00	240,403,200.00
210101	Үндсэн цалин	198,533,900.00	172,047,900.00
210102	Нэмэгдэл	53,326,400.00	53,326,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,088,000.00	11,088,000.00
210104	Урамшуулал	3,940,900.00	3,940,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>35,017,600.00</b>	<b>32,454,400.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,642,000.00	23,718,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,593,900.00	2,184,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,075,100.00	1,747,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	518,800.00	436,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,187,800.00	4,368,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>31,300,000.00</b>	<b>28,500,000.00</b>
210302	Түлш, халаалт	11,600,000.00	6,423,370.00
210304	Байрны түрээс	19,700,000.00	22,076,630.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,402,400.00</b>	<b>10,727,400.00</b>
210401	Бичиг хэрэг	3,498,700.00	2,887,900.00
210402	Тээвэр, шатахуун	4,484,000.00	3,268,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	622,600.00	679,200.00
210404	Ном, хэвлэл	0.00	192,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	370,800.00	315,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,426,300.00	3,384,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,620,000.00</b>	<b>4,561,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,350,000.00	4,561,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>159,519,817.00</b>	<b>502,903,876.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	278,800.00	239,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	159,241,017.00	502,664,276.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,456,929,350.00</b>	<b>1,876,199,500.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,429,580,025.00</b>	<b>1,721,816,712.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	735,432,937.00	1,055,708,958.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	693,547,088.00	665,607,754.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,349,325.00	154,382,788.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,349,325.00	154,382,788.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>10,521,000.00</b>	<b>27,945,900.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>10,521,000.00</b>	<b>27,945,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,521,000.00</b>	<b>27,945,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>10,521,000.00</b>	<b>27,945,900.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,521,000.00	27,945,900.00

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-10,521,000.00	-27,945,900.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,204,782,100.0</b>	<b>2,050,399,312.0</b>	93%
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,204,782,100.0	2,050,399,312.0	93%
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	336,015,500.0	328,582,600.00	98%
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	240,403,200.0	240,403,200.00	100%
Үндсэн цалин	172,047,900.0	172,047,900.00	100%
Нэмэгдэл	53,326,400.0	53,326,400.00	100%
Унаа хоолны хөнгөлөлт	11,088,000.0	11,088,000.00	100%
Урамшуулал	3,940,900.0	3,940,900.00	100%
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,454,400.0	32,454,400.00	100%
Тэтгэврийн даатгал	23,718,300.0	23,718,300.00	100%
Тэтгэмжийн даатгал	2,184,000.0	2,184,000.00	100%
ҮОМШӨ-ний даатгал	1,747,200.0	1,747,200.00	100%
Ажилгүйдлийн даатгал	436,800.0	436,800.00	100%
Эрүүл мэндийн даатгал	4,368,100.0	4,368,100.00	100%
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	35,925,900.0	28,500,000.00	79%
Гэрэл, цахилгаан	665,700.0	-	0%
Түлш, халаалт	7,589,000.0	6,423,370.00	85%
Цэвэр, бохир ус	71,200.0	-	0%
Байрны түрээс	27,600,000.0	22,076,630.00	80%
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,727,400.0	10,727,400.00	100%
Бичиг хэрэг	2,887,900.0	2,887,900.00	100%
Тээвэр, шатахуун	3,268,200.0	3,268,200.00	100%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	679,200.0	679,200.00	100%
Ном, хэвлэл	192,700.0	192,700.00	100%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	315,200.0	315,200.00	100%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,384,200.0	3,384,200.00	100%
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,566,000.0	4,561,000.00	100%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,566,000.0	4,561,000.00	100%
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11,938,600.0	11,936,600.00	100%
Бараа үйлчилгээний бусад зардал	241,600.0	239,600.00	99%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,697,000.0	11,697,000.00	100%
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,868,766,600.00	1,721,816,712.00	92%
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,868,766,600.00	1,721,816,712.00	92%
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,192,497,600.00	1,055,708,958.00	89%
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	675,752,200.00	665,607,754.00	98%

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	516,800.0	500,000.00	97%
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,204,782,100.0</b>	<b>2,050,399,312.0</b>	<b>93%</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,204,782,100.0</b>	<b>2,050,399,312.0</b>	<b>93%</b>
Улсын төсвөөс санхүүжих	2,204,782,100.0	2,050,399,312.0	93%
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>19.0</b>	<b>19.0</b>	
Удирдах ажилтан	1.0	1.00	100%
Гүйцэтгэх ажилтан	18.0	18.00	100%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>518,913,176.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	518,913,176.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	518,913,176.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	518,913,176.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		518,913,176.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>518,913,176.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	518,913,176.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	216,812,415.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	95,020,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	201,180,761.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,900,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Говь-Алтай аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэвэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Боловсролын газар нь нутаг дэвсгэрийнхээ боловсролын байгууллага, иргэдийг төрийн захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах, тэдний үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй Боловсрол, Шинжлэх Ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгасан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,021.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 40.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 32.4 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-ын 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Боловсролын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 528 хувиар буюу 785.3 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл 102.0 сая төгрөг болж өссөн нь тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн 4.7 сая, хувь хүний орлогын албан татварын 2.9 сая төгрөгийн, бусад харилцагч байгууллага, хувь хүнээс авах 69.4 сая төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой. Нэгээс дээш жилийн насжилттай шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын 22.9 сая төгрөгийн, байгууллагаас авах 1.9 сая төгрөгийн авлагатай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 4.2 сая төгрөг болж 14.1 сая төгрөгөөр буурсан нь тусгай зориулалттай материалыг Ерөнхий боловсролын сургуулиудад шилжүүлсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 38.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 47.8 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж, үйл ажиллагаандаа 38.8 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,381.5 сая төгрөг болж 765.8 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 27.9 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 5.8 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, Багшийн хөгжлийн ордны 762.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий барилгыг бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Тайлант онд "Ундарга-Алтай" ОНӨААТҮГ-т 30.8 сая төгрөгийн авто машиныг шилжүүлсэн ба тайлант оны эцэст 1,381.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 968.7 сая төгрөг болж 785.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 16.7 хувиар буюу

1,418.1 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 800.8 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 686.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Үүнд хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн дүн ороогүй болно.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 331.1 сая төгрөгөөр бууруулж, 355.3 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс бага байгаа нь цалингийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 3 хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 2,204.8 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,204.8 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,050.4 сая төгрөгийг зарцуулж 154.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,050.4 сая төгрөг буюу 93 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 7.4 сая төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг 136.8 сая төгрөгөөр, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийг 10.1 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 518.9 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба Засаг даргын нөөц хөрөнгөөс 95.0 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 201.8 сая төгрөг, НҮБ-ын Хүүхдийн сангаас санхүүжүүлсэн 216.8 сая төгрөгийн орлогыг тайлагнаж зарцуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн орлогыг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авалтын и-баримтыг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 173 мэдээллээс 173 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн, хугацаа хоцорсон 1 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 2 заалт бүхий зөрчил арилгах албан шаардлага хүргүүлснээс шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын авлагыг барагдуулахаар хууль хяналтын байгууллагад хандсан бол бусад шийдвэрийн хэрэгжилтийг хангуулсан байна.

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар нэмэлт санхүүжилтийн дансны орлогын зарцуулалт, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн зардал, тайлант онд авлагаар тусгасан бараа, ажил үйлчилгээ бодитоор ирсэн эсэх, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй.

Байгууллагын удирдах албан тушаалтан, 5 мэргэжилтнийг Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг, 43 дугаар зүйлийн 43.3 дахь заалтыг зөрчиж томилсон байна.

“Боловсролын мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын захирлын 2021 оны А/24 дүгээр тушаалаар контент боловсруулах лаборатори байгуулах 66 байгууллага тус бүрд 19.0 сая төгрөгийн санхүүжилт хуваарилсан нь шууд худалдан авалт хийх босго үнийг бууруулж шууд гэрээ хийх боломжийг бүрдүүлсэн гэж үзэж болохоор байна.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр “Боловсролын чанарыг сайжруулах” хөтөлбөрийн хүрээнд багш нарт 76.2 сая төгрөгийн шагнал олгосон байна.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 109.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 66.5 сая төгрөгийн алдааг залруулж, 3.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 39.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

##### 4.1 Залруулсан алдаа

Бараа материалын тайланг 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, бодитоор ирээгүй 64.1 сая төгрөгийн хөрөнгийг шууд зардлаар тайлагнасныг аудитын явцад байгууллагын удирдлага, нягтлан бодогч хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд залруулав. Мөн 2.2 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

##### 4.2 Төлбөрийн акт

Албан хаагчдад 3.8 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг илүү бодож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-тай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх, хэмжилт эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

##### 4.3 Албан шаардлага

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүй, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтны орон тоонд шинээр ажилтан авсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.2-т “шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх” гэж заасныг зөрчсөн, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг зөрчсөн, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын 23.0 сая төгрөгийн авлага санхүүгийн тайланд бүртгэлтэй, барагдаагүй байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.”, Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т “Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.”, Төрийн албаны тухай хуулийн 50.1-т “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр

чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайланд нэгээс дээш жилийн насжилттай 2.0 сая төгрөгийн авлага бүртгэлтэй, барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6-т “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 3.9 сая төгрөгийн илүү төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1-т “Аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.2-т “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.3-т “Бүх өр төлбөр” гэж заасныг зөрчсөн, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Аймгийн Говь-Алтай аймгийн Боловсролын газрын чиг үүрэгт хамаарах ажлыг ТББ-аар гүйцэтгүүлж 19.9 сая төгрөгийн төсөв зарцуулсан нь Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1<sup>1</sup>.4.” Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Байгууллагын нягтлан бодогч өөрийн хамаарал бүхий этгээд болох нөхрийн “Хас шанд” ХХК-аас 22,845.5 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөх алдаа зөрчилтэй асуудал байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Боловсролын газар	10	109.9	2	66.5	1	3.8	7	39.6	0	0

/сая төгрөгөөр/